



## МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУШААЛ

2021 оны 11 сарын 25 өдөр

Дугаар А-313

Улаанбаатар хот

### Банкны ажилтны суурь шаардлагын жишгийг батлах тухай


Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт, 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Монгол Улсын банкны салбарт ажиллахад тавигдах банкны ажилтны суурь шаардлагын жишиг”, “Шинэ банкирын онол, практик хосолсон болон мэргэшсэн банкирын сургалтын жишиг журам” болон “Банкны ажилтны суурь шаардлагын жишгийг хангуулах шинэ банкирын сургалтын ерөнхий хөтөлбөр”-ийг тус тус хавсралт ёсоор баталсугай.

2.Энэхүү тушаалаар батлагдсан банкны ажилтны суурь шаардлагын жишиг, сургалтын жишиг журам, хөтөлбөрийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг банкуудын гүйцэтгэх захирал нарт чиглэл болгосугай.

3.Олон нийтэд сурталчлан таниулах арга хэмжээ авахыг Удирдлага, төлөвлөлтийн газар (Ж.Батхуяг)-т даалгасугай.

ЕРӨНХИЙЛӨГЧ



БЛХАГВАСҮРЭН

14 1780



## **МОНГОЛ УЛСЫН БАНКНЫ САЛБАРТ АЖИЛЛАХАД ТАВИГДАХ БАНКНЫ АЖИЛТНЫ СУУРЬ ШААРДЛАГЫН ЖИШИГ**

### **НЭГ. НИЙТЛЭГ ЗҮЙЛ**

- 1.1 Банкны салбарт ажиллахад тавигдах банкны ажилтны суурь шаардлагын жишгийг хангаж ажилласнаар санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, харилцагч төвтэй санхүүгийн үйлчилгээг үзүүлэх, мэргэжлийн ёс зүйтэй банкны ажилтныг төлөвшүүлж, банкны салбар дахь итгэлцлийг бэхжүүлэх, урт хугацаанд санхүүгийн салбарын тогтвортой, хүртээмжтэй өсөлт хөгжлийг тасралтгүй дэмжих ач холбогдолтой.
- 1.2 Банкны салбарт ажиллахад тавигдах банкны ажилтны суурь шаардлагын жишгийг хангаж, батламж авах нь тухайн ажилтан мэдлэг ур чадвараа салбартаа хүлээн зөвшөөрүүлэх, цаашдын карьер хөгжилд нь дэмжлэг болох ач холбогдолтой.
- 1.3. Энэхүү суурь шаардлагын жишгийг банкны үндсэн үйл ажиллагаанд хамаарал бүхий чиг үүрэгтэй ажилтнууд хангаж ажиллана.
- 1.4 Монголбанкнаас зөвшөөрөл аван Монгол Улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж буй бүх банк хүний нөөц, боловсон хүчний бодлогодоо энэхүү суурь шаардлагын жишгийг удирдамж болгоно.
- 1.5 Банкинд ажиллахад тавигдах мэргэжлийн, ёс зүйн, санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах чиглэлийн суурь шаардлагын жишгийг хангасныг эрх бүхий байгууллага хамтран батламжилна.

### **ХОЁР. НЭР ТОМЬЁО**

- 2.1 “Банкны ажилтан” гэж Банкны тухай хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан, банкны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжид ажиллаж буй иргэнийг;
- 2.2 “Банкны ажилтны суурь шаардлагын жишиг” гэж банкны салбарт ажиллахад тавигдах мэдлэг, ур чадварын босго шалгуурыг ойлгоно. Энэ нь эрх бүхий байгууллагаас баталсан банкны салбарт ажиллахад шаардлагатай мэргэжлийн, ёс зүйн, санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах чиглэлийн эзэмшвэл зохих суурь мэдлэг, ур чадварын түвшнийг;
- 2.3 “Шинэ банкирын сургалт” гэж банкны ажилтны суурь шаардлагын жишгийг хангуулах зорилгоор явуулж буй онол, практик хосолсон сургалтыг;
- 2.3 “Банкны үндсэн үйл ажиллагаа” гэж бусдын мөнгөн хөрөнгийг хуримтлуулан хадгалж, өөрийн нэрийн өмнөөс зээл олгох, төлбөр тооцоо хийх зэрэг санхүүгийн зуучлалын үйл ажиллагааг;
- 2.4 “Мэргэшсэн банкирын сургалт” гэж тухайн чиглэлээр банкны салбарт карьераа ахиулахад шаардлагатай гүнзгийрүүлэн судлах сургалтыг ойлгоно. Энэхүү сургалтуудын ангилал, шатлалыг мэргэшсэн банкирын сургалтын хөтөлбөрөөр нарийвчлан тусгана.

## **ГУРАВ. БАНКНЫ АЖИЛТАНД ТАВИГДАХ МЭДЛЭГ, УР ЧАДВАРЫН СУУРЬ ШААРДЛАГЫН ЖИШИГ**

3.1 Мэдлэг ур чадварын суурь шаардлагын жишиг нь эдийн засаг, бизнесийн орчин, банкны бүтээгдэхүүн, үйлчилгээ, зээл төлбөр тооцоо, эрсдэлийн удирдлага, хууль журам, комплаенс, ёс зүй, цахим банкны үйл ажиллагаа зэрэг үндсэн сэдвүүдийг хамарсан байна.

Мэргэжлийн суурь шаардлагын жишиг:

- 3.1.1. Эдийн засгийн мөчлөг, санхүүгийн системд банк, санхүүгийн байгууллагын гүйцэтгэх чиг үүрэг, харилцан хамаарлыг тайлбарлах чадвартай;
- 3.1.2. Эдийн засгийн нөхцөл байдалд зохицуулан санхүүгийн шийдвэр гаргахад нь харилцагчид туслах, зөвлөх чадвартай;
- 3.1.3. Банкны тогтолцоо, үйл ажиллагааны онцлогийг бүрэн таньж мэдсэн байх;
- 3.1.4. Банкны үйл ажиллагаатай холбоотой Монгол Улсын холбогдох хууль журмыг хэрэглэх, тайлбарлах чадвартай;
- 3.1.4. Харилцагчтай хамтран ажиллах, бизнесийн хамтын ажиллагаа явуулах, түүнийг дуусгавар болохтой холбогдох хууль эрх зүйн зохицуулалтуудыг хэрэглэх, мөрдөж ажилладаг байх;
- 3.1.5. Банкны өдөр тутмын үйл ажиллагаанд учирч болзошгүй эрх зүйн эрсдэлийг тодорхойлох, урьдчилан сэргийлэх чадвартай;
- 3.1.6. Харилцагчид банкны бүтээгдэхүүн, үйлчилгээтэй холбоотой хууль эрх зүйн зохицуулалт, бусад нөхцөл байдлын талаар үнэн зөв, хэрэгцээт мэдээллийг өгөх чадвартай;
- 3.1.7. Төлбөр тооцооны төрлүүдийг харилцагчид тайлбарлах, тохиромжтой бүтээгдэхүүн санал болгох;
- 3.1.8. Хадгаламжийн бүтээгдэхүүнээс өөрийн санхүүгийн зорилгодоо тохируулан сонголт хийх, зөв шийдвэр гаргахад харилцагчид туслах, зөвлөх чадвартай;
- 3.1.9. Харилцагчийн зорилгод тохирсон зээлийн бүтээгдэхүүнийг санал болгох, зээлийн зөв шийдвэр гаргахад харилцагчид зөвлөх чадвартай;
- 3.1.10. Харилцагч санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээг цахимаар авахад шаардагдах бүх мэдээлэл зөвлөгөөг мэргэжлийн түвшинд үзүүлэх;
- 3.1.11. Банкны санхүүгийн тайланг уншиж, санхүүгийн байдлыг дүгнэх чадвартай;
- 3.1.12. Санхүүгийн тайлангаас хэрэгтэй тоон мэдээллийг олж, харилцагчид санхүүгийн шийдвэр гаргахад нь зөвлөх чадвартай;
- 3.1.13. Албан бичиг баримт боловсруулах стандартын тухай суурь ойлголттой, бичиг баримтыг хадгалах, стандартын дагуу архивлах чадвартай;

Банкны ажилтны ёс зүйн суурь шаардлагын жишиг:

- 3.2.1. Харилцагчийн санхүүгийн, бизнесийн болон хувийн мэдээллийг нууцлах, мэдээллийн аюулгүй байдлыг ханган ажиллах;

- 3.2.2. Харилцагчид санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээ, тэдгээртэй холбоотой шимтгэл хураамжийн талаарх мэдээллийг ил тод, тодорхой тайлбарлах;
- 3.2.3. Харилцагчтай харилцан зөвлөлдөж шийдвэрийг гаргуулах, харилцагчийн шийдвэр гаргалтад хөндлөнгийн нөлөөлөл дарамт үзүүлэхгүй байх;
- 3.2.4. Харилцагчийн аливаа санал, гомдлыг хуульд заасны дагуу шийдвэрлэж, харилцагчид гомдол саналын хариуг цаг тухайд өгөх;
- 3.2.5. Нууц бичиг баримтыг боловсруулах, хадгалах стандарт, нууц мэдээллийг хамгаалахтай холбоотой суурь мэдлэгтэй байх;
- 3.2.6. Комплаенсын тухай суурь ойлголттой байж, банкны комплаенсийн дүрэм, журам, ёс зүйн хэм хэмжээг дагаж мөрдөх;
- 3.2.7. Харилцагчийн үйлчилгээ, банкны ажилтны нийгмийн хариуцлага, ёс зүйн зарчмуудыг баримталж ажилладаг байх;
- 3.2.8. Мөнгө угаах, терроризмын эрсдэлийн талаар харилцагчид тайлбарлан ойлгуулах, түүнээс урьдчилан сэргийлэхэд нь зөвлөн туслах;
- 3.2.9. Мөнгө угаах, терроризмын эрсдэлээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хүрээнд харилцагчийг таньж мэдэхэд зайлшгүй шаардлагатай суурь мэдээллүүдийг мэддэг, харилцагчаас уг мэдээллүүдийг гаргуулан авч үйлчилгээ үзүүлдэг байх;

Санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах суурь шаардлагын жишиг:

- 3.3.1. Харилцагчид банкны бүтээгдэхүүн үйлчилгээг борлуулахдаа бодит хэрэгцээ шаардлагад үндэслэн зөвлөх, хөндлөн борлуулалт хийх чадвартай;
- 3.3.2. Харилцагчийн бизнесийн өдөр тутмын үйл ажиллагаа болон хувийн санхүүгийн нөхцөл байдалд учирч болзошгүй санхүүгийн болон эрх зүйн эрсдэлүүдийг тодорхойлох, урьдчилан сэргийлэх боломжуудын талаар зөвлөх чадвартай;
- 3.3.3. Харилцагчдад шаардлагатай мэдээллийг ил тод байдлаар богино хугацаанд, үр дүнтэй дамжуулах чадвартай;
- 3.3.4. Бусдын болон өөрийн сэтгэл хөдлөлийг ойлгох, бусдын хариу үйлдлийг мэдрэх, учир шалтгааныг ойлгож, харилцагчтай шударга хүндэтгэлтэй харилцах чадвартай;
- 3.3.5. Харилцагчтай үүсгэж болох аливаа маргаан, зөрчилдөөнийг хууль, журмын дагуу мэргэжлийн түвшинд шийддэг чадвартай;

#### **ДӨРӨВ. БАНКИРЫН МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТЫН ТҮВШИН БА АНГИЛАЛ**

- 4.1 Банкны ажилтны суурь шаардлагын жишгийг шинэ банкирын онол практик хосолсон сургалтад хамрагдаж, батламж авснаар хангасанд тооцно.
- 4.2 Банкны ажилтанд зайлшгүй олгох тасралтгүй сургалтад 2 жил тутамд Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх (МУТСТ) комплаенс, ёс зүй, банкны цахим үйл ажиллагааны чиглэлээр сургалтад сууж батламж авна.

4.3 Шинэ банкирын сургалт нь банкны салбарт дараах ур чадвар, төлөвшлийг олгох сургалтуудыг хөгжүүлэн олгоно:

- 4.3.1. Хувь хүний ур чадвар
- 4.3.2. Мэргэжлийн ур чадвар
- 4.3.3. Нийгмийн харилцааны ур чадвар
- 4.3.4 Ажил төлөвлөлт, зохион байгуулалтын ур чадвар
- 4.3.5 Тасралтгүй суралцах хандлага

4.4 Мэргэшсэн банкир хөтөлбөрийн хүрээнд банкны ажилтны ахисан түвшний сургалтыг чиг үүргийн дагуу ажилтны карьер хөгжилтэй уялдуулан дараах чиглэлүүдээр олгоно:

- 4.4.1. Менежмент, манлайлал
  - 4.4.1.1. Багийн ахлагч
  - 4.4.1.2. Салбарын захирал
  - 4.4.1.3. Газар, хэлтсийн захирал
  - 4.4.1.4. Дээд удирдлага
- 4.4.2. Борлуулалт
  - 4.4.2.1. Иргэдийн банкны зөвлөх
  - 4.4.2.2. Байгууллагын банкны зөвлөх
  - 4.4.2.3. ВИП зөвлөх, үүнд хөрөнгөө удирдахад зөвлөх орно
  - 4.4.2.4. Төслийн зөвлөх
  - 4.4.2.5. Үл хөдлөх хөрөнгийн зөвлөх
- 4.4.3. Арын оффис
  - 4.4.3.1. Зээл гаргах процесс
  - 4.4.3.2. Зээлийн шинжилгээ, үүнд эрсдэлийн шинжилгээ
  - 4.4.3.3. Бүтцийн өөрчлөлт
  - 4.4.3.4. Үл хөдлөх хөрөнгийн үнэлгээ
- 4.4.4. Бусад
  - 4.4.4.1. Маркетинг
  - 4.4.4.2. Хүний нөөц, үүнд шинэ банкны ажилтнуудын ментор
  - 4.4.4.3. Сургалт
  - 4.4.4.4. Төслийн удирдлага
  - 4.4.4.5. Комплаенс
  - 4.4.4.6. МУТСТ
  - 4.4.4.7. Цахим аюулгүй байдал
  - 4.4.4.8. Цахим банк

## **ТАВ. БУСАД**

5.1 Энэхүү мэргэжлийн суурь шаардлагын жишгийг хангуулах стандарт сургалтуудыг Шинэ Банк Санхүүгийн Академи нь шат дараатай зохион байгуулж батламжилна.

5.2 Банкны ажилтны суурь шаардлагын жишгийг хангасан ажилтны бүртгэлийг банк бүр дотроо, банкны системийн хэмжээнд Шинэ Банк Санхүүгийн Академи хариуцна.

5.3 Банкны ажилтны суурь шаардлагын жишгийг хангасан ажилтан ажлын байран дээр ёс зүйн зөрчил гаргаж, ажлаас халагдсан тохиолдолд ажил олгогч нь Шинэ Банк Санхүүгийн Академид ажлын 10 хоногт мэдээлнэ.

## ШИНЭ БАНКИРЫН ОНОЛ ПРАКТИК ХОСОЛСОН БОЛОН МЭРГЭШСЭН БАНКИРЫН СУРГАЛТЫН ЖИШИГ ЖУРАМ

### НЭГ. Нийтлэг үндэслэл

- 1.1 Энэхүү жишиг журмын зорилго нь Монгол Улсын банк, санхүүгийн салбарын хүний нөөцийн суурь чадавхыг “Шинэ банкирын онол, практик хосолсон сургалт” болон “Мэргэшсэн банкирын сургалт”-уудаар дамжуулан системтэйгээр хөгжүүлж, банкны үндсэн үйл ажиллагаанд оролцож буй ажилтнуудыг мэргэжлийн, ёс зүйн, санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр сургалтын цогц үйл ажиллагааны агуулга, хэлбэр, банкны ажилтанд тавих суурь шаардлагын жишгийг хангуулахтай холбогдсон үйл ажиллагаа, харилцааг зохицуулахад оршино.
- 1.2 Энэхүү жишиг журамд Иргэний хууль, Төв банк /Монголбанк/-ны тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль, Банкны тухай хууль, Төрийн бус байгууллагын тухай хууль болон бусад хууль тогтоомжийг баримтална.

### ХОЁР. Нэр томъёоны тодорхойлолт

Энэ жишиг журамд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно.

- 2.1. “Банкны ажилтан” гэж Банкны тухай хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан, банкны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжид ажиллаж буй иргэнийг;
- 2.2. “Банкны ажилтны мэргэжлийн сургалтад зайлшгүй хамрагдах ажилтан” гэж туслах үйлчилгээний ажилтнуудаас бусад банкны үндсэн үйл ажиллагаанд чиг үүргийн дагуу оролцдог бүх ажилтнуудыг;
- 2.3. “Банкны үндсэн үйл ажиллагаа” гэж бусдын мөнгөн хөрөнгийг хуримтлуулан хадгалж, өөрийн нэрийн өмнөөс зээл олгох, төлбөр тооцоо хийх зэрэг санхүүгийн зуучлалын үйл ажиллагааг;
- 2.4. “Банкны ажилтны суурь шаардлага жишиг” гэж эрх бүхий байгууллагаас баталсан банкны салбарт ажиллахад шаардлагатай мэргэжлийн, ёс зүйн, санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах чиглэлийн суурь мэдлэг, ур чадварын түвшнийг;
- 2.5. “Батламж” гэж сургалтын хөтөлбөрт хамрагдаж, зохих шаардлагын жишгийг хангаж, шалгалтад тэнцсэн оролцогчид олгох баримт бичгийг;
- 2.6. “Шинэ банкирын сургалт” гэж банкны ажилтны суурь шаардлагын жишгийг хангуулах зорилгоор явуулж буй онол, практик хосолсон сургалтыг;
- 2.7. “Мэргэшсэн банкирын сургалт” гэж тухайн чиглэлээр банкны салбарт карьераа ахиулахад шаардлагатай гүнзгийрүүлэн судлах сургалтыг;
- 2.8. “Ментор” гэж тухайн банкны хүний нөөц, сургалт, хөгжил хариуцсан ажилтан байх ба “Шинэ банкирын сургалт”-ын хөтөлбөр болон өөрийн байгууллага хооронд сургалт,

дадлагын тогтвортой үйл ажиллагааг ханган харилцан мэдээлэл солилцох байнгын үндсэн ажилтныг;

2.9. "Сургалтад оролцогч" гэж мэргэжлийн сургалтад хамрагдаж буй ажилтныг;

2.10. "Сургалтын орчин" гэж боловсролын стандартыг хэрэгжүүлэхэд шаардагдах материаллаг нөхцөл болон сурах, сургах харилцааг;

2.11. "Шалгалтын комисс" гэж Банк санхүүгийн академийн удирдлагын тушаалаар төгсөлтийн шалгалтыг зохион байгуулахаар томилогдсон бүрэлдэхүүнийг;

2.12. "Сургалтын хөтөлбөр" гэж тухайн сургалтын агуулгыг эзэмших суралцагчийн мэдлэг, ур чадвар, төлөвшилийн түвшин, түүнд хүрэх цогц үйл ажиллагааны ерөнхий зохион байгуулалтыг илэрхийлсэн баримт бичгийг;

2.13. "Сургалтын удирдлага" гэж Монголбанк, Германы Шпаркассэ банкны Монгол дахь сан, Монголын банкны Холбоо болон Банк, Санхүүгийн Академийн удирдлагаас бүрдсэн удирдлагын багийг;

2.14. "Чадамж" гэж хөдөлмөрийн орчинд ажил олгогчийн зүгээс тавих мэргэжлийн шаардлагыг биелүүлэх түвшинд суралцагчийн эзэмшсэн байвал зохих мэдлэг, чадвар, дадал, хөдөлмөрийн соёлын төлөвшлийг;

2.15. "Суурь шаардлагын жишгийг хангуулах нөхцөлийг хэрэгжүүлэх этгээд" гэж салбарын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн институт буюу Шинэ Банк Санхүүгийн Академийг;

### **ГУРАВ. Банкны ажилтны суурь шаардлагын жишиг**

3.1. Банкны ажилтны мэргэжлийн суурь шаардлагын жишиг:

3.1.1. Эдийн засгийн мөчлөг, санхүүгийн системд банк, санхүүгийн байгууллагын гүйцэтгэх чиг үүрэг, харилцан хамаарлыг тайлбарлах чадвартай;

3.1.2. Эдийн засгийн нөхцөл байдалд зохицуулан санхүүгийн шийдвэр гаргахад нь харилцагчид туслах, зөвлөх чадвартай;

3.1.3. Банкны тогтолцоо, үйл ажиллагааны онцлогийг бүрэн таньж мэдсэн байх;

3.1.4. Банкны үйл ажиллагаатай холбоотой Монгол Улсын холбогдох хууль журмыг хэрэглэх, тайлбарлах чадвартай;

3.1.4. Харилцагчтай хамтран ажиллах, бизнесийн хамтын ажиллагаа явуулах, түүнийг дуусгавар болохтой холбогдох хууль эрх зүйн зохицуулалтуудыг хэрэглэх, мөрдөж ажилладаг байх;

3.1.5. Банкны өдөр тутмын үйл ажиллагаанд учирч болзошгүй эрх зүйн эрдэлийг тодорхойлох, урьдчилан сэргийлэх чадвартай;

3.1.6. Харилцагчид банкны бүтээгдэхүүн, үйлчилгээтэй холбоотой хууль эрх зүйн зохицуулалт, бусад нөхцөл байдлын талаар үнэн зөв, хэрэгцээт мэдээллийг өгөх чадвартай;

3.1.8. Төлбөр тооцооны төрлүүдийг харилцагчид тайлбарлах, тохиромжтой бүтээгдэхүүн санал болгох;

3.1.9. Хадгаламжийн бүтээгдэхүүнээс өөрийн санхүүгийн зорилгодоо тохируулан сонголт хийх, зөв шийдвэр гаргахад харилцагчид туслах, зөвлөх чадвартай;

3.1.10. Харилцагчийн зорилгод тохирсон зээлийн бүтээгдэхүүнийг санал болгох, зээлийн зөв шийдвэр гаргахад харилцагчид зөвлөх чадвартай;

- 3.1.11. Харилцагч санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээг цахимаар авахад шаардагдах бүх мэдээлэл зөвлөгөөг мэргэжлийн түвшинд үзүүлэх;
- 3.1.12. Банкны санхүүгийн тайланг уншиж, санхүүгийн байдлыг дүгнэх чадвартай;
- 3.1.13. Санхүүгийн тайлангаас хэрэгтэй тоон мэдээллийг олж, харилцагчид санхүүгийн шийдвэр гаргахад нь зөвлөх чадвартай;
- 3.1.14. Албан бичиг баримт боловсруулах стандартын тухай суурь ойлголттой, бичиг баримтыг хадгалах, стандартын дагуу архивлах чадвартай;
- 3.2. Банкны ажилтны Ёс зүйн суурь шаардлагын жишиг:
- 3.2.1. Харилцагчийн санхүүгийн, бизнесийн болон хувийн мэдээллийг нууцлах, мэдээллийн аюулгүй байдлыг ханган ажиллах;
- 3.2.2. Харилцагчид санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээ, тэдгээртэй холбоотой шимтгэл хураамжийн талаарх мэдээллийг ил тод, тодорхой тайлбарлах;
- 3.2.3. Харилцагчтай харилцан зөвлөлдөж шийдвэрийг гаргуулах, харилцагчийн шийдвэр гаргалтад хөндлөнгийн нөлөөлөл дарамт үзүүлэхгүй байх;
- 3.2.4. Харилцагчийн аливаа санал, гомдлыг хуульд заасны дагуу шийдвэрлэж, харилцагчид гомдол саналын хариуг цаг тухайд өгөх;
- 3.2.5. Нууц бичиг баримтыг боловсруулах, хадгалах стандарт, нууц мэдээллийг хамгаалахтай холбоотой суурь мэдлэгтэй байх;
- 3.2.6. Комплаенсын тухай суурь ойлголттой байж, банкны комплаенсийн дүрэм журам ёс зүйн хэм хэмжээг дагаж мөрдөх;
- 3.2.7. Харилцагчийн үйлчилгээ, банкны ажилтны нийгмийн хариуцлага, ёс зүйн зарчмуудыг баримталж ажилладаг байх;
- 3.2.8. Мөнгө угаах, терроризмын эрсдэлийн талаар харилцагчид тайлбарлан ойлгуулах, түүнээс урьдчилан сэргийлэхэд нь зөвлөн туслалх;
- 3.2.9. Мөнгө угаах, терроризмын эрсдэлээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хүрээнд харилцагчийг таньж мэдэхэд зайлшгүй шаардлагатай суурь мэдээллүүдийг мэддэг, харилцагчаас уг мэдээллүүдийг гаргуулан авч үйлчилгээ үзүүлдэг байх;
- 3.3. Санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах суурь шаардлагын жишиг:
- 3.3.1. Харилцагчид банкны бүтээгдэхүүн үйлчилгээг борлуулахдаа бодит хэрэгцээ шаардлагад үндэслэн зөвлөх, хөндлөн борлуулалт хийх чадвартай;
- 3.3.2. Харилцагчийн бизнесийн өдөр тутмын үйл ажиллагаа болон хувийн санхүүгийн нөхцөл байдалд учирч болзошгүй санхүүгийн болон эрх зүйн эрсдэлүүдийг тодорхойлох, урьдчилан сэргийлэх боломжуудын талаар зөвлөх чадвартай;
- 3.3.3. Харилцагчдад шаардлагатай мэдээллийг ил тод байдлаар богино хугацаанд, үр дүнтэй дамжуулах чадвартай;
- 3.3.4. Бусдын болон өөрийн сэтгэл хөдлөлийг ойлгох, бусдын хариу үйлдлийг мэдрэх, учир шалтгааныг ойлгож, харилцагчтай шударга хүндэтгэлтэй харилцах чадвартай;
- 3.3.5. Харилцагчтай үүсгэж болох аливаа маргаан, зөрчилдөөнийг хууль, журмын дагуу мэргэжлийн түвшинд шийддэг чадвартай;
- 3.4. Суурь шаардлагуудын жишгийг хангах хугацаа:

- 3.4.1. Банкны ажилтнуудын суурь шаардлагын жишгийг хангах хугацаа тухайн ажилтны банкны салбарт ажилласан жилээс хамаарна.
- 3.4.2. Банкны салбарт шинээр орж буй ажилтнууд 1 жил хүртэлх хугацааны дотор суурь шаардлагын жишгүүдийг хангана.
- 3.4.2. Банкны салбарт 1-ээс дээш жил ажиллаж буй ажилтан энэхүү жишиг журам хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэх өдрөөс хойш 2 жилийн дотор суурь шаардлагын жишгүүдийг хангана.
- 3.4.3. Банкны салбарт харилцагчдад үйлчилдэг чиг үүрэгт хамаарах банкны ажилтнууд тухайн чиг үүрэгт шаардлагатай сургалтын хөтөлбөрт хэсэгчлэн хамрагдаж суурь шаардлагын жишгийг хангаж болно.
- 3.4.4. Харилцагчид зөвлөгөө өгөх чиг үүрэггүй, банкинд бодит ажилласан жил нь 5-аас дээш бол суурь шаардлагын жишгийг хангасанд тооцно.

#### **ДӨРӨВ. Суурь шаардлагын жишгийг хангах нөхцөл**

- 4.1. Суурь шаардлагын жишгийг хангах хөтөлбөрт хамрагдах шалгуур:
- 4.1.1. Арилжааны банкинд 1 жил хүртэл ажилласан банкны ажилтан;
  - 4.1.2. Арилжааны банкинд шинээр ажилд орж буй банкны ажилтан;
  - 4.1.3. Арилжааны банкинд ажилд орох хүсэлтэй иргэд;
- 4.2. Суурь шаардлагын жишгийг хангах нөхцөл, шалгалтын үйл ажиллагаа:
- 4.2.1. Шинэ Банк Санхүүгийн Академийн Мэргэжлийн эрх олгох зөвлөлөөс санал болгосон шалгалтын комисс шалгалтыг авна;
  - 4.2.2 Шалгалтын комиссын бүрэлдэхүүнийг тухай бүр Шинэ Банк санхүүгийн академийн Удирдах зөвлөлөөс батална.
  - 4.2.3 Шалгалтын комисс нь хараат бус, бие даасан байх нөхцөлийг хангана.
  - 4.2.4 Шалгалтын үйл ажиллагааны нарийвчилсан журмыг Шинэ Банк Санхүүгийн Академийн Удирдах зөвлөл батална.

#### **ТАВ. Суурь шаардлагын жишгийг хангах нөхцөлийг хэрэгжүүлэх этгээдийн эрх, үүрэг**

- 5.1. Суурь шаардлагын жишгийг хангах нөхцөлийг Монголбанк, Монголын Банкны Холбооноос хамтран баталсан цогц хөтөлбөрийн дагуу Шинэ Банк Санхүүгийн Академи хэрэгжүүлж, стандарт сургалтыг зохион байгуулна.
- 5.2. Энэ жишиг журмын 5.1-т заасан сургалтын ноу-хоу, сургалтын агуулга, мэдлэгийн хөрөнгө оруулалтыг ХБНГУ-ын Шпаркассэ банкны Монгол дахь сангаас гаргана.
- 5.3. Суурь шаардлагын жишгийг хангах нөхцөлийг хэрэгжүүлэх этгээд буюу Шинэ Банк Санхүүгийн Академийн эрх:
- 5.3.1. Стандарт сургалтыг тухай бүр, батлагдсан хуваарь, хүчин чадлын дагуу зохион байгуулах;
  - 5.3.2. Стандарт сургалтын хөтөлбөр, модулийг арилжааны банкны шинэ ажилтан болон арилжааны банкинд 5-аас дээш жил ажилласан банкируудын мэдлэг чадварын хэрэгцээнд тус тус үндэслэн боловсруулах;
  - 5.3.3. Стандарт сургалтын зардал, оролцогч бүрд ногдох төлбөрийн хэмжээг тогтоох;
  - 5.3.4. Шалгалтын үйл ажиллагааны журмыг боловсруулж батлах;

5.3.5. Суурь шаардлагын жишгийг хангах шалгалт авах комиссын бүрэлдэхүүнийг дотоод журмын дагуу томилж, батлах;

5.3.6. Суурь шаардлагын жишгийн шалгуурыг хангаж батламж авсан суралцагчдын мэдээллийн сан үүсгэж, тодорхой нөхцөл, журмын дагуу гуравдагч этгээдэд мэдээлэл дамжуулах;

5.3.7. Сургагч багшийн эрх олгох, сургагч багшийг бэлтгэх эрхтэй;

5.4. Суурь шаардлагын жишгийг хангах нөхцөлийг хэрэгжүүлэх этгээд буюу Шинэ Банк Санхүүгийн Академийн үүрэг:

5.4.1. Стандарт сургалтын модуль, хөтөлбөрийг эрх бүхий байгууллагаар хэлэлцүүлж баталгаажуулах;

5.4.2. Стандарт сургалт зохион байгуулахад шаардлагатай нөхцөлөөр хангах;

5.4.3. Сургалтын оролцогчид, шалгалтын үйл ажиллагаатай холбоотой програм хангамж, мэдээллийн сан, дэд бүтцийг бий болгож, тогтмол удирдаж, шинэчлэх;

5.4.4. Сургалтын оролцогчид, шалгалтын үйл ажиллагаатай холбоотой програм хангамж, мэдээллийн сангийн нууцлалыг хадгалж, мэдээллийн аюулгүй байдлын шаардлагыг хангаж ажиллана;

5.5. Суурь шаардлагын жишгийг хангах нөхцөлийг хэрэгжүүлэх этгээд буюу Банк Санхүүгийн Академийн хариуцлага:

5.5.1. Сургалтын оролцогчид, шалгалтын үйл ажиллагаатай холбоотой програм хангамж, мэдээллийн санд хадгалагдсан мэдээллийг эрх бүхий байгууллагаас хуульд заасны дагуу шаардсанаас бусад тохиолдолд тухайн этгээдийн нууцлалыг бусдад задруулахгүй байх;

5.5.2. Хууль, тогтоомжид заасан бусад хариуцлага;

### **ЗУРГАА. Банкуудын эрх, үүрэг**

6.1. Банкууд энэ жишиг журмын 2.2-т заасан бүх ажилтнаа дээрх суурь шаардлагыг хангуулах сургалтад хамруулж холбогдох сургалтын төлбөрийг шилжүүлэх үүрэгтэй байна.

6.2. Сургалтад хамрагдах ажилтнуудын ажлын байран дахь зохион байгуулалтыг хийж, сургалтад бүрэн хамрагдах боломжоор ханган ажиллана.

6.3. Тухайн банк өөрийн банкинд шинээр ажилд орж буй ажилтныг суурь шаардлагын жишгийг хангах, хөтөлбөрт хамрагдах хугацаанд (*9 сарын хугацаанд*) дадлагажих ажилтнаар ажиллуулж, холбогдох цалин хөлсийг олгоно.

6.4. “Шинэ банкирын онол, практик хөсөлсөн сургалт”-ын салшгүй хэсэг болох практик дадлагыг тухайн модулийн хүрээнд өөрийн банкны салбар, нэгж дээр зохион байгуулах.

6.5. Энэхүү жишиг журмын 2.8-д заасан менторыг томилох.

6.6. Мөн энэхүү жишиг журмын 2.6 болон 2.7-д заасан сургалтын хөтөлбөрүүдэд сургагч багш нараар хамтран ажиллах сонирхолтой хүний нөөцөөр хамтран ажиллах.

6.7. Түүнчлэн дээр дурдсан сургалтын хөтөлбөрүүдийн шалгалтын комиссын бүрэлдэхүүнд оролцон, хяналтын үйл ажиллагаанд оролцох.

## ДОЛОО. Бусад

- 7.1. Энэхүү жишиг журамд эрх бүхий этгээдүүд нэмэлт өөрчлөлт оруулж болно.
- 7.2. Жишиг журмын зорилгыг хангах хүрээнд банкны ажилтанд тавигдах суурь шаардлагын жишгийн дагуу банкны ажилтны чиг үүргээс хамаарсан сургалтын хөтөлбөртэй байна.
- 7.3. “Шинэ банкирын сургалт”-ын модулиудын агуулга, арга зүйд өөрчлөлт оруулах бол ХБНГУ-ын Шпаркассэ банкны Монгол дахь санд мэдэгдэнэ.
- 7.4. Эдгээрийн хөтөлбөрүүдийг амжилттай төгссөн ажилтнуудад батламж олгох ба тус батламж нь МУ-ын банк санхүүгийн салбарт хүлээн зөвшөөрөгдсөн байна.
- 7.5. Энэ жишиг журмын хэрэгжилтэд Монголын Банкны Холбоо, өөрийн гишүүдийн ашиг сонирхлын үүднээс нэгдсэн хяналт тавьж ажиллана.
- 7.6. Энэ жишиг журмыг үе шаттайгаар хэрэгжих хугацааг сургалтын хөтөлбөрийн удирдлага болон банкуудын удирдлага, тэдгээрийг төлөөлөх байгууллагууд хамтран тодорхойлно.
- 7.7. Энэхүү жишиг журмын хэрэгжилтийг хангуулах үйл ажиллагаанд хөтөлбөрийг удирдах байгууллагууд техникийн, санхүүгийн болон бусад нөөцүүдээр хангаж, хамтран ажиллана.

Монголбанкны Ерөнхийлөгчийг 2021 оны  
... 11 сарын 25-ны өдрийн  
А-313 дугаар тушаалын хавсралт



**Банкны ажилтны суурь шаардлагын жишгийг хангуулах шинэ  
банкирын сургалтын ерөнхий хөтөлбөр**

Улаанбаатар 2021

## АГУУЛГА

1. СУРГАЛТЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА, ЗОРИЛГО	15
2. СУРГАЛТААР ОЛГОХ ЕРӨНХИЙ МЭДЛЭГ, УР ЧАДВАР, ХАНДЛАГА	15
3. СУРГАЛТЫН АГУУЛГА	16
4. СУРГАЛТЫН ҮНЭЛГЭЭ, ШАЛГАЛТ	25
5. АШИГЛАХ МАТЕРИАЛ	26

## **1. СУРГАЛТЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА, ЗОРИЛГО**

### **1.1. Сургалтын танилцуулга**

Энэхүү сургалтын хөтөлбөр нь Монголбанк, Германы Шпаркассэ банкны Монгол дахь сан, Монголын Банкны Холбоо хамтран хэрэгжүүлж буй төслийн үргэлжлэл болох “Монгол Улсад банкны ажилтны суурь шаардлагын жишгийг хангуулах шинэ банкирын онол, практик хосолсон сургалт” -ын агуулгад үндэслэн Санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, банкны ажилтны чадавхыг сайжруулах үүднээс банкируудад суурь мэдлэг, ур чадварыг олгох баримт бичиг юм.

### **1.2. Сургалтын зорилго**

Энэхүү сургалтын хөтөлбөр нь шинэ банкируудыг банкны салбарт ажиллахад шаардлагатай мэргэжлийн, ёс зүйн болон санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах чиглэлийн мэдлэг, ур чадварыг олон улсын жишигт нийцүүлэн олгох замаар тасралтгүй сургаж, хөгжүүлэх зорилготой юм.

## **2. СУРГАЛТААР ОЛГОХ ЕРӨНХИЙ МЭДЛЭГ, УР ЧАДВАР, ХАНДЛАГА**

**2.1.** Энэхүү сургалтын онцлог нь онол, практикийн нягт уялдаа холбоог хангаж, банкируудын ур чадварыг хөгжүүлэх, бие даан суралцах чадвар, мэргэжлийн мэдлэг, ур чадварыг сайжруулах явдал юм.

**2.2.** Энэхүү сургалтад хамрагдсанаар банкны салбарт санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, харилцагч төвтэй санхүүгийн үйлчилгээг үзүүлэх, мэргэжлийн ёс зүйтэй банкны ажилтныг төлөвшүүлж, банкны салбар дахь итгэлцлийг бэхжүүлэх, урт хугацаанд санхүүгийн салбарын тогтвортой, хүртээмжтэй өсөлт хөгжлийг тасралтгүй дэмжих ач холбогдолтой.

Сургалтад амжилттай хамрагдаж, батламж авах нь тухайн ажилтан мэдлэг ур чадвараа салбартаа хүлээн зөвшөөрүүлэх, цаашдын карьер хөгжилд нь дэмжлэг болох ач холбогдолтой.

**2.3.** Сургалтаар дараах ерөнхий мэдлэг, ур чадвар, хандлагыг эзэмшүүлнэ. Үүнд:

- Мэдлэг:

- Эдийн засгийн нөхцөл байдал, эдийн засаг дах банкны салбарын оролцоо (Төв банк, Арилжааны банк), гүйцэтгэх үүргийн талаарх мэдлэг, ойлголт;
- МУ-ын банкны үйл ажиллагаатай холбоотой хууль журам, тэдгээрийн нэр томъёоны тайлбар, банк болон харилцагч хоорондын хууль эрх зүйн харилцааны талаарх мэдлэг;
- Банкны нягтлан бодох бүртгэлийн үндсэн ойлголт;
- Банкны үндсэн үйл ажиллагаа болох хадгаламж, харилцах данс, зээл, төлбөр тооцооны талаарх мэдлэг.
- Хөдөлмөрийн аюулгүй байдал ба эрүүл ахуй (ХАБЭУ)
- Комплайнс, МУТСТ
- Ёс зүй / Банкны ажилтны кодекс
- Цахим аюулгүй байдал

- Ур Чадвар:

- Харилцагчид үр дүнтэй зөвлөх ур чадвар;
- Борлуулалтын ур чадвар;

- Харилцааны ур чадвар;
  - Зөрчилдөөнийг шийдвэрлэх ур чадвар;
  - Бие даан суралцах чадвар;
  - Багаар ажиллах чадвар;
  - Илтгэх чадвар;
- Хандлага
    - Харилцагчийн оронд өөрийгөө тавьж бодох, харилцагчид зөвлөгөө өгөх чин хүсэлтэй байх;
    - Санхүү, эдийн засгийн нөхцөл байдал, банкны бүтээгдэхүүн үйлчилгээний талаар харилцагчийг үнэн зөв мэдээллээр хангахыг эрмэлзэх;
    - Аливаа үйл ажиллагааг холбогдох хууль, дүрэм, журам зааврын дагуу зохион байгуулах ёс зүйн хэм хэмжээг эрхэмлэх;
    - Харилцагчийн санхүүгийн шийдвэр гаргалтад эергээр нөлөөлөх, дэмжлэг үзүүлэх;
    - Харилцагчтай чанарыг эрхэмлэж хүндэтгэн харилцах;
    - Харилцагчаа эрхэмлэж, банкны ажилтны ёс зүйн хэм хэмжээг баримтлах;
    - Шинийг санаачлах, хэрэгжүүлэхийг эрмэлзэх;
    - Сурч хөгжих, өөрийгөө дайчлах.

### **3. СУРГАЛТЫН АГУУЛГА**

#### **3.1. Сургалтын төвч агуулга**

Сургалтаар банкны салбарт орсон шинэ банкирт банкны мэргэжилтний мэдвэл зохих эдийн засаг, нийгэм, санхүүгийн талаарх ойлголтыг онол, практик хослуулан хүргэхийн сацуу сургалтыг танхим, цахим түүнчлэн бие даан суралцах хэлбэрээр зохион байгуулан тухайн банкирыг өөрийн чиг үүргээ гүйцэтгэх чадамжтай болгохыг зорино. Агуулгын хүрээнд дараах зүйлийг судална. Үүнд:

- 3.1.1. Банкир өөрийн мэдлэг чадвараа ахиулах, харилцагчид зөвлөхийн тулд тухайн үеийн нийгэм, эдийн засгийн нөхцөл байдлыг мэдэж байх хэрэгтэй болдог. Иймээс сургалтын эхний хэсэгт эдийн засгийн үндсэн ойлголтууд болон санхүүгийн тогтолцооны талаар авч үзнэ.
- 3.1.2. Харилцагчдад санал болгох банк, санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ, түүний онцлог, ач холбогдлын талаар судална.
- 3.1.3. Банкны нягтлан бодох бүртгэлийн тухай ойлголт, банкны санхүүгийн тайлан, түүний бүтэц, агуулга, дансны тухай үзнэ.
- 3.1.4. Харилцагчид үр дүнтэй зөвлөх, тэдэнтэй зөв боловсон, соёлтой харилцахад туслах харилцагчийн хэрэгцээ, зан төлөвийг тодорхойлох, хэрхэн түүнд нийцүүлэн харилцах талаар авч үзнэ.
- 3.1.5. Үйл ажиллагаагаа хуулийн хүрээнд явуулахын тулд холбогдох хууль тогтоомжийг мэддэг байх шаардлагын үүднээс банкны салбарын эрх зүйн зохицуулалтын талаар судална.
- 3.1.6. Компаенс, Мөнгө угаах болон терроризмтой тэмцэх, хөдөлмөрийн аюулгүй байдал ба эрүүл ахуй (ХАБЭА), цахим аюулгүй байдал, банкны ажилтны ёс зүй зэрэг сэдвүүдийг бие даан цахимаар судална.

- 3.1.7. Сургалтын хөтөлбөр нь тухай бүр банкны салбарын хэрэгцээ шаардлагад үндэслэн сургалтын агуулга, сэдвүүдийг өөрчлөн шинэчлэх зэргээр хөгжүүлэлт хийгдэх боломжтой байна.
- 3.1.8. Энэхүү сургалтын хөтөлбөрт орсон модуль, хичээлүүд цаашид сайжран хөгжүүлэгдэнэ.
- 3.1.9. Бусад дэлгэрэнгүй мэдээллийг энэхүү хөтөлбөрийн хавсралт болох 3.2 хэсэгт нарийвчлан оруулсан болно.

### 3.2. Модулиудаар олгох мэдлэг, ур чадвар, сургалтын хугацаа

Модуль (Өдөр/цаг)	Модулиар олгох мэдлэг	Модулиар олгох ур чадвар	Явцын шалгалт
Модуль-1. Эдийн засгийн нөхцөл байдал ( <i>манхим</i> )	<ul style="list-style-type: none"> <li>• Санхүүгийн системийн нийгэм, эдийн засагт гүйцэтгэх үүрэг, нөлөө;</li> <li>• Эдийн засгийн салбарууд, эдийн засгийн мөчлөг, мөчлөгийн үе шат;</li> <li>• Эдийн засгийн өсөлт, Нэрлэсэн ба бодит ДНБ, нэг хүнд ногдох ДНБ;</li> <li>• Мөнгө, түүний үүрэг, үнийн өсөлт;</li> <li>• Зах зээлийн төрөл, онцлог;</li> <li>• Банк, санхүүгийн байгууллагын бүтээгдэхүүн үйлчилгээ;</li> <li>• Санхүүгийн салбарын зохицуулагч байгууллагуудын зорилго, үйл ажиллагаа.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Эдийн засгийн мөчлөгийн хүрээнд эдийн засгийн нэгж, банкны үүргийг тайлбарлах;</li> <li>• Эдийн засгийн гол нэр томьёог тайлбарлах;</li> <li>• Эдийн засгийн нөхцөл байдлыг тодорхойлох;</li> <li>• Эдийн засгийн нөхцөл байдалд зохицуулан санхүүгийн шийдвэр гаргахад нь харилцагчид туслах, зөвлөх;</li> </ul>	<p>Явцын шалгалттай</p> <p>Явцын шалгалтын дүн төгсөлтийн шалгалтад орох босго оноо болно.</p>
Модуль-2. Хууль эрх зүйн үндэс ( <i>манхим</i> )	<ul style="list-style-type: none"> <li>• Банкны салбар дахь Төв банкны үүрэг, эрх зүйн зохицуулалт;</li> <li>• Арилжааны банкны мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт;</li> <li>• Банкны салбарын эрх зүйн зохицуулалт, үйлчилж буй хууль;</li> <li>• Монгол Улсын Үндсэн хуульд тусгагдсан банк, санхүүгийн үйл ажиллагаатай холбогдох заалтууд;</li> <li>• Үүрэг ба хариуцлагын тухай суурь ойлголт;</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Банкны үйл ажиллагаатай холбоотой Монгол Улсын холбогдох хууль журмыг хэрэглэх, тайлбарлах;</li> <li>• Өдөр тутмын үйл ажиллагааг гүйцэтгэхдээ хүчин төгөлдөр мөрдөгдөж буй холбогдох хууль, журмын заалтуудыг баримтлан ажиллах;</li> <li>• Харилцагчтай хамтран ажиллах, бизнесийн хамтын ажиллагаа явуулах, түүнийг дуусгавар болохтой холбогдох</li> </ul>	<p>Явцын шалгалттай</p> <p>Явцын шалгалтын дүн төгсөлтийн шалгалтад орох босго оноо болно.</p>
Онол 2/20	Практик 0/0		
Онол 2/20	Практик 1/8		

		<ul style="list-style-type: none"> <li>• Нууц бичиг баримтыг боловсруулах, хадгалах стандарт, нууц мэдээллийг хамгаалахтай холбоотой суурь мэдлэг;</li> <li>• Хууль ба засаглал: Банк, санхүүгийн системийн зээлийн үйл ажиллагаанд баримтлах хуулийн зохицуулалт, шүүх болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны процесс, зарчим;</li> <li>• Банкны өдөр тутмын үйл ажиллагаанд үүсэж болзошгүй эрх зүйн эрсдэл;</li> <li>• Өв залгамжлал;</li> <li>• Хамтын ажиллагааны хууль эрх зүйн зохицуулалт.</li> </ul>	<p>хууль эрх зүйн зохицуулалтуудыг хэрэглэх, мөрдөж ажиллах;</p> <ul style="list-style-type: none"> <li>• Банкны өдөр тутмын үйл ажиллагаанд учирч болзошгүй эрх зүйн эрсдэлийг тодорхойлох, урьдчилан сэргийлэх;</li> <li>• Харилцагчид банкны бүтээгдэхүүн, үйлчилгээгэй холбоотой хууль эрх зүйн зохицуулалт, бусад нөхцөл байдлын талаар мэдээлэл өгөх.</li> </ul>	
<p>Модуль-3. Харилцах данс, хадгаламж, төлбөр тооцоо (танхим)</p>		<ul style="list-style-type: none"> <li>• Харилцах данс, түүний үүрэг</li> <li>• Нэмэлт бүтээгдэхүүн борлуулалтын үүрэг</li> <li>• Төлбөр тооцоо, түүний хэлбэр, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, карт</li> <li>• Төлбөр тооцооны технологи ба хэрэгжүүлэлт</li> <li>• Олон улсын банкны дансны дугаар (IBAN)</li> <li>• Харилцаа холбооны систем (SWIFT)</li> <li>• Хуримтлалын ач холбогдол, аюулгүй байдал, хадгаламжийн төрөл</li> <li>• Огтолцоо худалдааны суурь ойлголт</li> <li>• Борлуулалтын арга техник</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Харилцах дансаар дамжуулан хөндлөн борлуулалт хийх;</li> <li>• Төлбөр тооцооны төрлүүдийг харилцагчид тайлбарлах, тохиромжтой бүтээгдэхүүн санал болгох /Давхар борлуулалтын худалдааны арга техник/;</li> <li>• Дотоод, гадаад шилжүүлэг хийх;</li> <li>• Хуримтлалын ач холбогдол, давуу талыг харилцагчид тайлбарлан ойлгуулах;</li> <li>• Хадгаламжийн бүтээгдэхүүнээс өөрийн санхүүгийн зорилгодоо тохируулан сонголт хийх, зөв</li> </ul>	<p>Явцын шалгалттай Явцын шалгалтын дүн төгсөлтийн шалгалтад орох босго оноо болно.</p>
<p>Онол 5/40</p>	<p>Практик 3/16</p>			

		<ul style="list-style-type: none"> <li>● Хуурамч болон муу мөнгөн тэмдэгийг ялгах, хадгалах, устгах тухай суурь ойлголт</li> <li>● ХБНГУ-ын Шпаркассэ банкны сангийн “Хадгаламжийн тоглоом”-оор дамжуулан симуляцийн орчинд бодит мэт мэдлэгээ баталгааж, суралцах</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>● Хадгаламжийн нээх данс нээх, өөрчлөлт оруулах, данс хаах;</li> <li>● Харилцах данс нээх, хөглөх, хаах;</li> <li>● Хадгаламжийн хүү тооцох;</li> </ul>	<p>шийдвэр гаргахад харилцагчид туслах, зөвлөх;</p> <ul style="list-style-type: none"> <li>● Хадгаламжийн нээх данс нээх, өөрчлөлт оруулах, данс хаах;</li> <li>● Харилцах данс нээх, хөглөх, хаах;</li> <li>● Хадгаламжийн хүү тооцох;</li> </ul>
<p>Модуль-4. Зээлийн үйл ажиллагаа (танхим)</p>		<ul style="list-style-type: none"> <li>● Зээлийн хэрэгцээ шаардлага, ач холбогдол, зээлийн төрөл;</li> <li>● Зээлийн зардлын тооцоолол;</li> <li>● Зээлийн үйл ажиллагааны үе шат;</li> <li>● Зээлийн болон санхүүгийн тайлангийн шинжилгээ;</li> <li>● Зээлийн борлуулалтын арга техник;</li> <li>● Санхүүгийн лизингийн суурь ойлголт;</li> <li>● Зээлийн эрсдэлийн удирдлага, зээлийн хяналт;</li> <li>● Зээлдэгчийн зээлжих болон төлбөр гүйцэтгэх чадвар;</li> <li>● Зээлийн барьцаа, барьцаа хөрөнгийн үнэлгээний зарчим, аргачлал;</li> <li>● Зээлийн тайлан, мэдээ.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>● Харилцагчийн зорилгод тохирсон зээлийн бүтээгдэхүүнийг санал болгох;</li> <li>● Зээлийн зөв шийдвэр гаргахад нь харилцагчид зөвлөх, туслах;</li> <li>● Зээлдэгчийн зээлжих болон төлбөр гүйцэтгэх чадвар, барьцаа хөрөнгийг үнэлэх;</li> <li>● Зээлийн санал боловсруулах;</li> <li>● Зээлийн судалгаа хийх;</li> <li>● Зээлийн тайлан мэдээ гаргах;</li> <li>● Зээлийн хүү тооцох.</li> </ul>	<p>Явцын шалгалттай</p> <p>Явцын шалгалтын дүн төгсөлтийн шалгалтад орох босго оноо болно.</p>
<p>Онол 5/40</p>	<p>Практик 3/16</p>			

<p>Модуль-5. Нягтлан бодох бүртгэлийн үндэс (танхим)</p>	<p>Онол 3/24</p> <p>Практик 1/8</p>	<ul style="list-style-type: none"> <li>● Банкны нягтлан бодох бүртгэлийн журам, хэрэглээ</li> <li>● Тооллого, тооллогын бүртгэл</li> <li>● Санхүүгийн тайлангийн бүрэлдэхүүн</li> <li>● Баланс, баланс дахь үзүүлэлтийн өөрчлөлт</li> <li>● Орлогын тайлан</li> <li>● Мөнгөн гүйлгээний тайлан</li> <li>● Данс, дансны ангилал, ажил гүйлгээний бүртгэл</li> <li>● ХБНГУ-ын Шпаркассэ банкны сангийн “Бичил бизнесийн тоглоом”-оор дамжуулан симуляцийн орчинд бодит мэт мэдлэгээ багатгаж, суралцах</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>● Банкны санхүүгийн тайланг уншиж, санхүүгийн байдлыг дүгнэх;</li> <li>● Санхүүгийн тайлангаас хэрэгтэй тоон мэдээллийг олж, санхүүгийн шийдвэр гаргахдаа ашиглах;</li> <li>● Тооллого хийх, бүртгэх;</li> <li>● Банкны энгийн ажил гүйлгээг бүртгэх, дансны бичилт хийх;</li> <li>● Бичил бизнесийн үйл ажиллагааг ойлгох, санхүүгийн тайланг унших.</li> </ul>	<p>Явцын шалгалттай Явцын шалгалтын дүн төгсөлтийн шалгалтад орох босго оноо болно.</p>
<p>Модуль-6 Харилцагчид үр дүнтэй зөвлөх, санхүүгийн бүтээгдэхүүн борлуулах (танхим)</p> <p>Онол Практик</p>	<ul style="list-style-type: none"> <li>● Хүний хэрэгцээ, зан төлөв</li> <li>● Харилцагчийн үйлчилгээ</li> <li>● Харилцагч ба банкны зөвлөхийн харилцаанд нөлөөлөх хүчин зүйлс</li> <li>● Харилцагчид зөвлөгөө өгөх арга</li> <li>● Үгэн болон үгэн бус харилцаа, харилцааны загварууд</li> <li>● Асуулт тавих арга ухаан</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>● Бусдын яриаг бүрэн анхаарч сонсох, хэлсэн үгийн цаад утгыг зөв ойлгоход цаг зарцуулах, зохистой асуулт асуух, тохиромжгүй үед бусдын яриаг таслахгүй байх;</li> <li>● Бусдад шаардлагагай мэдээллийг богино хугацаанд, үр дүнтэй дамжуулах;</li> </ul>	<p>Явцын шалгалттай Явцын шалгалтын дүн төгсөлтийн шалгалтад орох босго оноо болно.</p>	

8/64	3/16	<ul style="list-style-type: none"> <li>● Харилцагчтай холбоо тогтооход анхаарах зүйлс</li> <li>● Борлуулалт хийх үр чадвар, борлуулалтын үе шат</li> <li>● Борлуулалтын арга техник</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>● Бусдын болон өөрийн сэтгэл хөдлөлийг ойлгох, бусдын хариу үйлдлийг мэдрэх, учир шалтгааныг ойлгох;</li> <li>● Харилцагчтай идэвхтэй харилцах аргыг зөв сонгож хэрэглэх;</li> <li>● Харилцагчийг сонгох, тохирсон бүтээгдэхүүнийг санал болгох;</li> <li>● Биеийн хэлэмжээ удирдах.</li> </ul>	
Модуль-7. Комплаенс <i>(Бие даан суралцах цахим сургалт)</i>	<ul style="list-style-type: none"> <li>● Банк, санхүүгийн байгууллагын комплаенс, түүний эрсдэлийн тухай ойлголт</li> <li>● Комплаенсийн бодлого, үндсэн зарчим</li> <li>● Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлээс сэргийлэх арга</li> <li>● Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын болон дотоодын эрх зүйн орчин</li> <li>● Мөнгө угаахтай тэмцэх олон улсын байгууллагуудын зөвлөмжүүд</li> <li>● Санхүүгийн мэдээллийн алба, түүний чиг үүрэг, үйл ажиллагаа</li> <li>● Харилцагчийн болон хувь хүний мэдээллийн хамгаалалт</li> <li>● Мэдээллийн аюулгүй байдлын удирдлага</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>● Банк, санхүүгийн байгууллагын комплаенсийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх;</li> <li>● Комплаенсийн үндсэн зарчмуудыг үйл ажиллагаандаа баримтлан ажиллах;</li> <li>● Харилцагчийн болон хувь хүний мэдээллийн аюулгүй байдлыг хангах;</li> <li>● Мөнгө угаах, терроризмын эрсдэлийн талаар харилцагчид тайлбарлан ойлгуулах, түүнээс урьдчилан сэргийлэхэд нь зөвлөн туслах;</li> <li>● Комплаенсийн ач холбогдол, үр нөлөөг ойлгож, үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх.</li> </ul>	Явцын шалгалттай. Явцын шалгалтын дүн төгсөлтийн шалгалтад орох босго оноо болно.	
Модуль-8.	<ul style="list-style-type: none"> <li>● Ёс зүйн тухай үндсэн ойлголт</li> </ul>		Явцын шалгалттай.	

<p>Ёс зүй (Бие даан суралцах цахим сургалт)</p>	<ul style="list-style-type: none"> <li>• Банк санхүүгийн байгууллагуудын ёс зүйн дүрэм</li> <li>• Банкны нийгмийн хариуцлага, ёс зүйн зарчим</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Банкны ажилтны нийгмийн хариуцлага, ёс зүйн зарчмуудыг баримтлан ажиллах.</li> </ul>	<p>Явцын шалгалтын дүн төгсөлтийн шалгалтад орох босго оноо болно.</p>
<p>Модуль-9. ХАБЭА (Бие даан суралцах цахим сургалт)</p> <p>8 цаг (Үүнээс 75 минут нь тест)</p>	<ul style="list-style-type: none"> <li>• Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай ерөнхий ойлголт</li> <li>• Хөдөлмөрийн тухай хууль</li> <li>• Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль</li> <li>• Үйлдвэрлэлийн осолд хүргэдэг аюулгүй хүчин зүйлс, урьдчилан сэргийлэлт</li> <li>• Онцгой байдал</li> <li>• Ажлын байран дахь эрүүл мэндэд сөргөөр нөлөөлдөг хүчин зүйлсийн төрлүүд, мэргэжлээс шалтгаалах өвчин</li> <li>• Ажлын хувцас, хувийн хамгаалах хэрэгслүүдийн төрөл, зохистой хэрэглээ</li> <li>• Ажлын байран дахь осол, өвчлөл үүсгэж болзошгүй хүчин зүйлсийг таньж илрүүлэх, мэдээлэх, бууруулж арилгахад ажилтны үүрэг оролцоо</li> <li>• Ажил эхлүүлэхээс өмнө эрсдэлийн үнэлгээ хийх арга</li> </ul> <p><i>to be developed in the future</i></p>	<ul style="list-style-type: none"> <li>• Осолд өртөгсдөл үзүүлэх анхны тусламж;</li> <li>• Ажилтны зан үйлтэй холбоотой өвчлөл, түүний урьдчилан сэргийлэлт.</li> </ul>	<p>Явцын шалгалттай. Явцын шалгалтын дүн төгсөлтийн шалгалтад орох босго оноо болно.</p>
<p>Модуль 10. Цахим аюулгүй байдал</p>	<p><i>to be developed in the future</i></p>		<p>Явцын шалгалтын дүн төгсөлтийн</p>

(Бие даан суралцах цахим сургалт)			шалгалтад орох босго оноо болно.
Модуль 11. МУГСТ-СFT (Бие даан суралцах цахим сургалт)	<i>to be developed in the future</i>		Явцын шалгалтын дүн төгсөлтийн шалгалтад орох босго оноо болно.
Модуль-12. Төгсөлтийн шалгалт бичгээр	Модулиар олсон мэдлэгийг бичгийн шалгалтаар бататгана		
Модуль-13. Төгсөлтийн шалгалт амаар	Модулиар олсон ур чадварыг ам шалгалтаар бататгана		

#### 4. СУРГАЛТЫН ҮНЭЛГЭЭ, ШАЛГАЛТ

Үнэлгээний төрөл	Үзүүлэлт	Оноо	Тайлбар
<b>1. Явцын үнэлгээ:</b> <ul style="list-style-type: none"> <li>Нэгдсэн үнэлгээний 100% буюу 100 оноо нь Явцын үнэлгээ байна.</li> <li>Явцын үнэлгээний 70%-ийг (70 оноо) авсан тохиолдолд төгсөлтийн шалгалт өгөх эрх үүснэ.</li> </ul>			
Явцын үнэлгээ – 100 оноо (100%)	Ирц, идэвх (10%)	10	Суралцагч сургалтад бүрэн хамрагдсан байна.
	Бие даалт (10%)	10	Суралцагч заасан хугацаанд багтаан Ёс зүй болон Комплаенсийн хичээлийг бие даан судалж, шалгалт өгсөн байна.
	Явцын шалгалт (50%)	50	Модуль бүр мэдлэг бататгах явцын шалгалттай байна.  Суралцагч явцын бүх шалгалтыг өгсөн байна.
	Дадлагын үнэлгээ (30%)	30	Суралцагчийн практик сургалтын явц, үр дүнг “Дадлагын үнэлгээний хуудас”-аар дадлага хариуцсан ажилтан үнэлж, ментор гарын үсэг зурж баталгаажуулна.
<b>2. Төгсөлтийн шалгалт</b> <ul style="list-style-type: none"> <li>Нэгдсэн үнэлгээний 100% буюу 100 оноо сургалтын үнэлгээ байна.</li> </ul>			
Төгсөлтийн шалгалт – 100 оноо (100%)	Бичгийн шалгалт (40%)	40	Төгсөлтийн шалгалтын удирдамжийн дагуу шалгалтыг авна. Аман шалгалтыг үнэлгээний хуудсаар үнэлнэ.
	Аман шалгалт (60%)	60	
<b>3. Нэгдсэн үнэлгээ</b> <ul style="list-style-type: none"> <li>Явцын үнэлгээ (1/3) болон төгсөлтийн шалгалтын (2/3) онооны нийлбэрээр нэгдсэн үнэлгээ гарна.</li> <li>Явцын болон төгсөлтийн шалгалтын дүнг Батламжийн хавсралтад бичнэ.</li> <li>Төгсөлтийн бичгийн шалгалтад доод тал нь 60% тэнцсэн мөн аман шалгалтад тэнцсэн тохиолдолд батламж гардана. Түүнчлэн аман шалгалтад тэнцээгүй тохиолдолд тухайн оролцогч төгсөлтийн шалгалтад тэнцээгүй гэж үзнэ.</li> </ul>			

## **5. АШИГЛАХ МАТЕРИАЛ**

- 5.1. Банкны ажилтны суурь шаардлага хангуулах шинэ банкирын онол, практик хосолсон сургалтын гарын авлага, 2020 он;
- 5.2. Тайлангийн дэвтэр, 2021 он (Банкны ажилтны суурь шаардлага хангуулах шинэ банкирын онол, практик хосолсон сургалтын);
- 5.3. Холбогдох хууль, эрх зүйн баримтууд;
- 5.4. Комплаенс, Ёсзүй, ХАБЭА, цахим аюулгүй байдал болон МУТСТ сэдвүүдээр бие даан суралцах цахим контентууд;
- 5.5. Сургагч багшийн гарын авлага
- 5.6. Сургалтын явцад ашиглах суралцагчдын материал
- 5.7. Шалгалтын материал
- 5.8. Батламж
- 5.9. Бусад

Огноо:

2021.11.23

Баримт бичгийн төрөл: Албан бичиг

Танилцсан: Ерөнхийлөгч

Дэд Ерөнхийлөгч

Хянасан: Ерөнхий эдийн засагч

ХЭЗГ-ын захирал

ОНСБТ-ийн захирал

Боловсруулсан:

ОНСБТ-ийн эдийн засагч

Б.Лхагвасүрэн

Г.Энхтайван

Д.Ган-Очир

Д.Аюуш

Б.Одонтунгалаг

Д.Гантогтох

## Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаал

..... оны ..... сарын ..... өдөр

Дугаар .....

Улаанбаатар хот

### Банкны ажилтны суурь шаардлагын жишгийг батлах тухай

Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт, 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Монгол Улсын банкны салбарт ажиллахад тавигдах банкны ажилтны суурь шаардлагын жишиг”, “Шинэ банкирын онол, практик хосолсон болон мэргэшсэн банкирын сургалтын жишиг журам” болон “Банкны ажилтны суурь шаардлагын жишгийг хангуулах шинэ банкирын сургалтын ерөнхий хөтөлбөр”-ийг тус тус хавсралт ёсоор баталсугай.
2. Энэхүү тушаалаар батлагдсан банкны ажилтны суурь шаардлагын жишиг, сургалтын жишиг журам, хөтөлбөрийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг банкуудын гүйцэтгэх захирал нарт чиглэл болгосугай.
3. Олон нийтэд сурталчлан таниулах арга хэмжээ авахыг Удирдлага, төлөвлөлтийн газар (Ж.Батхуяг)-г даалгасугай.

МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ

Б.ЛХАГВАСҮРЭН

Огноо:

2021.11.16

Баримт бичгийн төрөл: Албан бичиг

Танилцсан: Ерөнхийлөгч

Дэд Ерөнхийлөгч

Хянасан: Ерөнхий эдийн засагч

ХЭЗГ-ын захирал

ОНСБТ-ийн захирал

Боловсруулсан:

ОНСБТ-ийн эдийн засагч

Б.Лхагвасүрэн

Г.Энхтайван

Д.Ган-Очир

Д.Аюуш

Б.Одонтунгалаг

Д.Гантогтох

## Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаал

..... оны ..... сарын ..... өдөр

Дугаар .....

### Банкны ажилтны суурь шаардлагын жишгийг батлах тухай

Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт, 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, ~~28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:~~

1. “Монгол Улсын банкны салбарт ажиллахад тавигдах банкны ажилтны суурь шаардлагын жишиг”, “Шинэ банкирын онол, практик хосолсон болон мэргэшсэн банкирын сургалтын жишиг журам” болон “Банкны ажилтны суурь шаардлагын жишгийг хангуулах шинэ банкирын сургалтын ерөнхий хөтөлбөр”-ийг тус тус хавсралт ёсоор баталсугай.
2. Энэхүү тушаалаар батлагдсан банкны ажилтны суурь шаардлагын жишиг, сургалтын жишиг журам, хөтөлбөрийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг банкуудын Гүйцэтгэх захирал нарт чиглэл болгосугай.
3. ~~Журам~~ Олон нийтэд сургалчлан таниулах арга хэмжээ авахыг Удирдлага, төлөвлөлтийн газар (Ж.Батхуяг)-т даалгасугай.

МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ

Б.ЛХАГВАСҮРЭН

*Төв Банкны Ерөнхийлөгчийн тушаал*  
*Улаанбаатар хот*  
*БОМ*  
*Хянасан, танилцсан, баримт бичгийн төрөл*  
*Д.Аюуш*  
*Д.Ган-Очир*  
*Б.Одонтунгалаг*  
*Д.Гантогтох*  
*ХЭЗГ-ын захирал*  
*ОНСБТ-ийн захирал*  
*ОНСБТ-ийн эдийн засагч*